

II.МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН.

II.1. Малын тооны өсөлт. 2002 оны эцэст улсын хэмжээгээр 23.9 сая толгой мал тоологдож, 2001 оныхоос 8.4 хувь буюу 2177.8 мянган толгойгоор, бодод шилжүүлснээр 9.0 хувь буюу 710.4 мянгаар тус тус буурлаа. 2001 оныхоос хонь 1300.7 мянга, ямаа 456.5 мянга, адуу 202.9 мянга, үхэр 185.3 мянга, тэмээ 32.2 мянгаар тус тус буурсан байна. (Хавсралт 7, 8, 10)

Хүснэгт 3

Малын тоо


мян.тол

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2002/2001	
								%	зөрүү
Бодоор *	10 185.6	10 683.2	11 151.5	11 432.6	9 839.2	7 877.7	7 167.3	91.0	- 710.4
Толгойн тоо	29 300.1	31 292.3	32 897.5	33 568.9	30 227.5	26 075.3	23897.6	91.6	-2 177.8
Тэмээ	357.9	355.4	356.5	355.6	322.9	285.2	253.0	88.7	- 32.2
Адуу	2 770.5	2 893.2	3 059.1	3 163.5	2 660.7	2 191.8	1988.9	90.7	- 202.9
Үхэр	3 476.3	3 612.9	3 725.8	3 824.7	3 097.6	2 069.6	1884.3	91.0	- 185.3
үүнээс: сарлаг	763.9	833.9	813.4	852.5	728.3	494.5	426.0	86.1	- 68.5
Хонь	13 560.6	14 165.6	14 694.2	15 191.3	13 876.4	11 937.3	10636.6	89.1	-1 300.7
Ямаа	9 134.8	10 265.3	11 061.9	11 033.9	10 269.8	9 591.3	9134.8	95.2	- 456.5

*Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

Малын тооны өсөлт, бууралт


Зураг 3



Улаанбаатар хот, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Дундговь, Хөвсгөл, Сүхбаатар аймгууд малаа нийт дүнгээр нь 12.0-130.8 мян.толгойгоор өсгөсний дотор Сүхбаатар, Дундговь аймгууд малаа таван төрөл дээр өсгөв. (Хавсралт 10)

Сүүлийн жилүүдэд цас зудтай, хүндрэлтэй өвөлжсөн Увс, Ховд, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын малын тоо 105.2-719.5 мян. толгойгоор буурчээ.

Бүсээр авч үзвэл: Баруун бүсийн нийт мал 2001 оныхоос 1.1 сая буюу 14.6 хувиар, Хангайн бүсийнх 1.0 сая буюу 11.0 хувиар, Төвийн бүсийнх 0.3 сая буюу 4.4 хувиар буурч, харин Зүүн бүсийнх 140.0 мян. толгой буюу 3.9 хувиар өслөө. (Хавсралт 10)



Хүснэгт 4

Малын тооны өсөлт, бууралтад голлон нөлөөлсөн үзүүлэлтүүд

мян.тол

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2002/2001	
								%	зөрүү
Бойжуулсан төл 100 эхээс бойжуулсан төл	9 047.5	9 537.3	9 907.3	10 220.9	8 273.3	7 370.7	6808.7	92.4	- 562.0
Том малын зүй бус хорогдол	78	81	76	74	59	56	60	107.1	4.0
Лээлтэгч малын Хээл хаясан	586.8	617.7	785.7	800.1	3 491.2	4 758.9	2917.6	61.3	-1 841.3
Сүлжээний малын Хээл хаясан	11 772.1	13 095.5	14 154.4	13 898.5	13 244.3	11 386.2	10479.1	92.0	- 907.1
Сүлжээний малын Хээл хаясан	450.8	540.1	532.2	654.5	1 205.5	1 019.9	875.1	85.8	- 144.8
Сүлжээний малын Хээл хаясан	873.5	1 042.6	967.8	1 258.5	1 494.4	1 364.8	1417.6	103.9	52.8

Байгаль, цаг уурын хүндрэлээс гадна малын тооны өсөлт, бууралтанд голлон нөлөөлдөг үзүүлэлтүүдийг авч үзвэл: 2002 онд том малын зүй бус хорогдол, хээл хаясан малын тоо зэрэг нь 2001 оныхоос буурсан хэдий ч хээлтэгч мал, бойжуулсан төлийн тоо багассан байна.

Хүснэгт 5

1993 оноос хойших малын өсөлт, бууралт

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	6	3	6	6	4	6
Буурсан жилийн тоо	4	7	4	4	6	4
1993 оныхоос өссөн хэмжээ (мян.тол)	3 027.8					3 027.8
1993 оныхоос буурсан хэмжээ (мян.тол)	-4 304.9	- 114.7	- 201.4	-846.2	-3 142.6	

1993-2002 оны хооронд мал сүргийн тоо 6 жилд нь өсч, 4 жилд нь буурч байсан байна.

Таван төрлийн малын өсөлт бууралтыг 2001 онтой харьцуулан аймгаар авч үзвэл: тэмээ Архангай, Дорноговь, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон зэрэг 9 аймагт, адуу Дорнод, Дундговь, Сүхбаатар, Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр зэрэг 6 аймагт, үхэр Дундговь, Сүхбаатар, Улаанбаатар, Говьсүмбэр зэрэг 4 аймагт, хонь Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Говьсүмбэр зэрэг 5 аймагт, ямаа Архангай, Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Улаанбаатар, Говь-Сүмбэр зэрэг 14 аймагт тус тус өсчээ.

Хүснэгт 6

Малын тоо, толгой хүрсэн дээд хэмжээ

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	33 568.9	1999	33 568.9	1999
Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	3 163.4	1999	3 163.4	1999
Үхэр	3 824.7	1999	3 824.7	1999
Хонь	15 936.4	1941	15 191.3	1999
Ямаа	11 061.9	1998	11 061.9	1998


Нийт малын тооны өсөлт, бууралт, /аймгаар, бүсээр/

Аймаг, нийслэл	Толгойн тоо (мян.тол)							2002/2001	
	1996	1997	1998	1999	2000	2001	2002	%	зөрүү
Дүн	29300.1	31292.3	32897.5	33568.9	30227.5	26075.3	23897.6	91.6	-2177.8
БАРУУН БҮС									
Дүн	9 687.3	9 971.2	9 798.6	9 665.3	8 702.4	7 587.2	6 482.2	85.4	-1 105.1
БӨ	1405.8	1 519.4	1 345.9	1 362.4	1 310.4	1 297.8	1 234.2	95.1	- 63.6
ГО	2087.2	2 112.5	2 113.1	2 113.2	2 035.1	1 714.7	1 010.5	58.9	- 704.2
ЗА	2474.5	2 556.5	2 603.6	2 432.0	1 941.3	1 486.7	1 443.2	97.1	- 43.5
УВ	1764.9	1 856.3	1 940.1	1 889.8	1 579.3	1 575.6	1 470.4	93.3	- 105.2
ХО	1954.9	1 926.5	1 795.9	1 867.9	1 836.3	1 512.4	1 323.9	87.5	- 188.5
Нийт малд эзлэх %	33.1	31.9	29.8	28.8	28.8	29.1	27.1	-	- 2.0
ХАНГАЙН БҮС									
Дүн	9 810.9	10 652.8	11 439.1	11 958.6	10 711.7	8 683.3	7 724.6	89.0	- 958.7
АР	1725.1	1 924.2	2 119.3	2 335.5	2 216.1	1 836.1	1 748.8	95.2	- 87.3
БХ	2233.1	2 428.0	2 511.3	2 475.1	2 375.7	1 581.7	862.2	54.5	- 719.5
ӨВ	2550.1	2 718.2	2 921.5	2 956.6	2 159.0	1 869.1	1 665.4	89.1	- 203.7
ХӨ	1976.9	2 152.3	2 295.8	2 418.2	2 269.6	1 770.0	1 900.8	107.4	130.8
БУ	1202.6	1 309.8	1 458.9	1 609.3	1 522.8	1 457.6	1 387.7	95.2	- 69.9
ОР	123.1	120.3	132.3	163.9	168.5	168.8	159.7	94.6	- 9.1
Нийт малд эзлэх %	33.5	34.0	34.8	35.6	35.4	33.3	32.3	-	- 1.0
ТӨВИЙН БҮС									
Дүн	6 710.5	7 322.8	7 946.2	7 980.9	6 792.6	6 003.4	5 737.3	95.6	- 266.1
ГС	110.7	117.8	135.7	136.5	112.5	65.0	80.0	123.1	15.1
ДО	922.6	963.2	1 017.8	1 110.2	1 036.6	838.3	825.8	98.5	- 12.5
ДУ	1844.8	2 025.7	2 212.8	2 105.2	1 282.8	1 397.4	1 475.0	105.6	77.6
ӨМ	1320.8	1 508.4	1 603.8	1 608.9	1 489.6	1 209.6	909.1	75.2	- 300.4
СЭ	506.6	522.5	569.4	622.6	654.5	645.4	683.4	105.9	38.0
ТӨ	1867.9	2 048.4	2 238.5	2 218.1	2 022.1	1 668.0	1 598.0	95.8	- 70.0
ДА	137.1	136.8	168.2	179.4	194.5	179.7	166.0	92.4	- 13.7
Нийт малд эзлэх %	22.9	23.4	24.2	23.8	22.5	23.0	24.0	-	1.0
ЗҮҮН БҮС									
Дүн	2 785.6	3 044.3	3 412.6	3 724.7	3 790.1	3 579.9	3 720.0	103.9	140.1
ХЭ	1150.5	1 254.0	1 388.7	1 462.3	1 471.4	1 356.7	1 378.5	101.6	21.8
ДД	594.2	657.2	735.7	811.8	826.2	794.1	825.4	103.9	31.3
СҮ	1040.9	1 133.1	1 288.2	1 450.6	1 492.5	1 429.1	1 516.1	106.1	87.0
Нийт малд эзлэх %	9.5	9.7	10.4	11.1	12.5	13.7	15.6	-	1.8
УЛААНБААТАР									
УБ	305.8	301.2	301.0	239.4	230.6	221.4	233.5	105.5	12.1
Нийт малд эзлэх %	1.0	1.0	0.9	0.7	0.8	0.8	1.0	-	0.1

Нийт малын дүнд аймгуудын малын эзлэх хувийн жинг авч үзвэл Хөвсгөл аймаг 8.0 хувь, Архангай 7.3 хувь, Өвөрхангай 7.0, Төв 6.7 хувь, Сүхбаатар 6.3 хувь, Увс, Дундговь аймгууд 6.2 хувийг тус тус эзэлж байна.

Бүс нутгаар ангилан үзвэл: Зүүн бүс болон Улаанбаатар хотоос бусад бүсэд нийт малын тоо буурсан бөгөөд нийт малын 27.1 хувь нь Баруун, 32.3 хувь нь Хангай, 24.0 хувь нь Төв, 15.6 хувь нь Зүүн, 1.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. (Хавсралт 7)

Зураг 5




2002 онд нийт малд адуу, хонины эзлэх хувийн жин 0.1-1.3 пунктээр буурч, ямааны эзлэх хувийн жин 1.4 пунктээр өссөн бөгөөд ямааны эзлэх хувийн жин жилээс жилд өссөөр байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	1.2	1.1	1.1	1.1	1.1	1.1	1.1
Адуу	9.4	9.3	9.3	9.4	8.8	8.4	8.3
Үхэр	11.9	11.5	11.3	11.4	10.2	7.9	7.9
Хонь	46.3	45.3	44.7	45.2	45.9	45.8	44.5
Ямаа	31.2	32.8	33.6	32.9	34.0	36.8	38.2

Зураг 6

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жин, 2002 онд



Улсад нийт малын тоо болон ямаагаар Хөвсгөл, тэмээгээр Өмнөговь, адуу, үхрээр Архангай, хониор Төв аймгууд тэргүүн байр эзэлж байна. (Хавсралт 5)
Бүсээр авч үзвэл: Нийт мал, адуу, үхэр, хониор Хангайн бүс, тэмээгээр Төвийн бүс, ямаагаар Баруун бүс тэргүүлж байна.

Хүснэгт 9

Малын тоогоор улсад тэргүүлж байсан аймгууд

		1996	1997	1998	1999.0	2000	2001	2002
Бүгд	малын тоо	2 550.1	2 718.2	2 921.5	2956.6	2 375.7	1 869.1	1 900.8
	аймгийн нэр	ӨВ	ӨВ	ӨВ	ӨВ	БХ	ӨВ	ХӨ
Тэмээ	малын тоо	92.9	95	97.7	98.8	92.8	82.3	72.0
	аймгийн нэр	ӨМ	ӨМ	ӨМ	ӨМ	ӨМ	ӨМ	ӨМ
Адуу	малын тоо	261.6	280.3	302.7	303.6	273.3	216.7	197.7
	аймгийн нэр	ТӨ	ТӨ	ТӨ	ТӨ	АР	АР	АР
Үхэр	малын тоо	415.5	442.1	458.5	482.2	428.6	277.3	253.4
	аймгийн нэр	ХӨ	ХӨ	ХӨ	ХӨ	АР	АР	АР
Хонь	малын тоо	1320.8	1347.6	1387.9	1423.1	1101.2	911.1	806.6
	аймгийн нэр	ЗА	ЗА	ӨВ	ӨВ	ТӨ	ӨВ	ТӨ
Ямаа	малын тоо	1053.5	1191.4	1252.3	1199.3	1190.0	878.8	725.0
	аймгийн нэр	БХ	БХ	БХ	БХ	БХ	ГО	ХӨ

Манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 6 дугаар, тэмээгээр 12, ямаагаар 12, хониор 17, үхрээр 55 дугаар байранд орж байна.

Ази тивд адуугаар 2 дугаар, тэмээгээр 4, хониор 6, ямаагаар 7, үхрээр 15 дугаар байранд орж байна.

Адуу, тэмээ, ямааны тоо (мян.тол)

Улсын нэр	Адууны тоо	Улсын нэр	Тэмээний тоо	Улсын нэр	Ямааны тоо
1.Хятад	8,855	1.Сомали	6,100	1.Хятад	137,717
2.Бразил	6,400	2.Судан	3,100	2.Энэтхэг	120,560
3.Мексик	6,250	3.Мавритан	1,183	3.Пакистан	48,575
4.АНУ	6,150	4.Пакистан	1,100	4.Судан	37,346
5.Аргентин	3,300	5.Энэтхэг	1,030	5.Бангладеш	33,500
6.Монгол	3,163	6.Этиоп	1,030	6.Иран	27,000
7. Этиоп	2,750	7.Кени	825.0	7.Нигери	24,500
8. Колумби	2,300	8.Чад	677.0	8.Эттиоп	16,850
9. Орос	1,312	9.Саудын араб	422.0	9.Индонези	15,200
10. Казахстан	1,083	10.Нигер	392.0	10.Бразил	12,600
		11.Мали	365.0	11.Сомали	12,500
		12.Монгол	356.0	12.Монгол	11,034

Тайлбар: Дэлхийн улсуудын малын тоог 1998 оноор авсан болно.

Манай улс дэлхийд нэг хүн амд ногдох адуу, ямаагаар тэргүүн байр, тэмээ, хониор 3 дугаар байранд тус тус тус орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог улс орнуудыг үзүүлбэл: (толгой)

Адуугаар		Тэмээгээр		Хониор		Ямаагаар	
1. Монгол	1.32	Сомали	0.60	Шинэ Зеланд	12.5	Монгол	4.62
2. Аргентин	0.09	Мавритан	0.47	Австрали	6.5	Мавритан	1.63
3. Казахстан	0.07	Монгол	0.15	Монгол	6.3	Сомали	1.35
4. Мексик	0.07	Судан	0.11	Уругвай	5.4	Судан	1.32
5. Колумби	0.06	Чад	0.09	Судан	1.5	Мали	0.80

II.2. Хувийн (амины) малын тоо. 2002 онд хувийн малын тоо 23.3 сая толгойд хүрч, нийт малын 97.4 хувийг эзлэх боллоо. Тэмээний 97.7, адууны 98.2, үхрийн 98.4, хонины 96.2, ямааны 98.5 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо өмнөх оныхоос толгойн дүнгээр 8.1 хувь буюу 2.1 саяар, бодод шилжүүлснээр 8.9 хувь буюу 0.7 саяар буурсан байна. (Хавсралт 9, 11)

Хүснэгт 10

Хувийн малын өсөлт, бүс нутаг, аймаг, нийслэлээр

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2002/2001	
								%	зөрүү
ДҮН	27 365.0	29 529.0	31 356.2	32 278.8	29 236.6	25335.6	23280.0	91.9	-2 055.5
БАРУУН БҮС									
Дүн	9 350.1	9 696.7	9 577.6	9 509.2	8 588.3	7497.1	6419.9	85.6	-1 077.2
БӨ	1 381.3	1 494.7	1 330.7	1 349.3	1 299.9	1287.7	1 224.9	95.1	- 62.8
ГО	2 038.7	2 070.7	2 077.7	2 079.0	2 006.6	1696.7	1 004.3	59.2	- 692.4
ЗА	2 408.3	2 505.6	2 560.1	2 404.4	1 924.0	1470.7	1 429.0	97.2	- 41.7
УВ	1 679.5	1 780.7	1 880.7	1 847.5	1 550.7	1549.4	1 450.8	93.6	- 98.6
ХО	1 842.3	1 845.0	1 728.4	1 829.0	1 807.1	1492.6	1 310.9	87.8	- 181.7
ХАНГАЙН БҮС									
Дүн	9 397.2	10 283.3	11 145.8	11 713.7	10 553.1	8571.5	7641.2	89.1	- 930.3
АР	1 697.8	1 900.8	2 096.7	2 316.0	2 199.5	1822.2	1738.0	95.4	- 84.2
БХ	2 155.2	2 359.3	2 477.0	2 445.7	2 351.6	1568.9	857.1	54.6	- 711.9
БУ	1 096.5	1 210.0	1 382.0	1 543.1	1 473.5	1420.4	1360.1	95.8	- 60.3
ӨВ	2 427.4	2 611.8	2 829.8	2 881.6	2 137.0	1854.2	1655.8	89.3	- 198.4
ХӨ	1 923.6	2 102.1	2 246.5	2 377.1	2 234.0	1745.5	1876.2	107.5	130.7
ОР	96.7	99.3	113.8	150.2	157.5	160.3	154.0	96.1	- 6.3
ТӨВИЙН БҮС									
Дүн	5 937.0	6 597.6	7 287.2	7 429.0	6 379.9	5719.3	5499.8	96.2	- 219.5
ГС	67.6	79.1	96.9	106.9	94.0	59.1	74.4	125.8	15.3
ДО	817.2	867.4	926.4	1 018.9	960.5	783.3	776.7	99.2	- 6.6
ДУ	1 789.9	1 970.5	2 157.8	2 063.5	1 266.3	1382.1	1460.5	105.7	78.3
ӨМ	1 275.0	1 458.5	1 555.6	1 564.2	1 459.3	1182.1	892.6	75.5	- 289.6
ДА	102.8	103.8	139.3	153.7	173.5	165.2	150.5	91.1	- 14.7
СЭ	331.4	371.1	442.4	511.8	566.6	582.4	634.5	108.9	52.1
ТӨ	1 553.1	1 747.2	1 968.8	2 010.0	1 859.7	1565.1	1510.6	96.5	- 54.5
ЗҮҮН БҮС									
Дүн	2 426.0	2 695.4	3 077.4	3 408.3	3 500.3	3338.1	3497.5	104.8	159.4
СҮ	937.8	1 042.5	1 209.6	1 377.7	1 423.1	1371.4	1458.5	106.4	87.1
ХЭ	1 004.4	1 103.3	1 231.0	1 316.1	1 338.3	1254.1	1291.5	103.0	37.4
ДД	483.8	549.6	636.8	714.5	738.9	712.6	747.5	104.9	34.9
УЛААНБААТАР									
УБ	254.7	256.0	268.2	218.6	215.0	209.6	222.0	105.9	12.4

Бүсээр авч үзвэл: баруун бүсийн нийт малын 99.0 хувь, Хангайн бүсийн нийт малын 98.9 хувь, Төвийн бүсийн нийт малын 95.9 хувь, Зүүн бүсийн нийт малын 94.0 хувь, Улаанбаатар хотын малын 94.1 хувь нь тус тус хувийн мал байна. Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл 44.0 хувь нь хонь, 38.6 хувь нь ямаа, 8.0 хувь нь үхэр, 8.4 хувь нь адуу, 1.1 хувь нь тэмээ байна.

Хувийн малтай өрх, тэдгээрийн малын тоо, төрлөөр

	Малтай өрхийн тоо	Бүгд	үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	262.3	8 242.9	88.2	1 108.1	1457.5	3 684.7	1 904.4
1991	288.9	14 002.6	186.3	1 492.1	1896.6	7 209.4	3 218.2
1992	301.5	18 081.1	253.7	1 728.0	2237.4	9 589.1	4 272.9
1993	289.7	22 565.2	335.0	2 026.8	2503.5	11 902.0	5 797.9
1994	289.2	24 527.2	343.3	2 279.0	2811.8	12 133.8	6 959.3
1995	283.9	26 447.2	349.7	2 532.0	3140.4	12 194.1	8 231.0
1996	278.3	27 365.2	342.6	2 670.6	3323.4	12 184.6	8 844.0
1997	279.7	29 529.0	343.8	2 807.4	3485.3	12 912.0	9 980.5
1998	275.0	31 356.3	346.4	2 982.6	3613.5	13 630.1	10 783.8
1999	270.0	32 278.7	346.4	3 097.3	3733.2	14 306.5	10 795.3
2000	268.7	29 236.7	315.5	2 609.4	3028.3	13 206.0	10 077.5
2001	256.6	25 335.6	278.3	2 152.2	2031.8	11 439.0	9 434.2
2002	243.2	23 280.0	247.2	1 953.0	1 853.4	10 232.4	8 994.1

2002 оны иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл: 31-50 малтай өрхийн тоо нэмэгдэж, бусад бүлгийн малтай өрхийн тоо буурсан байна. 2002 онд малтай өрхөд 100 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 69.1 хувь болж өнгөрсөн оныхоос 1.6 пунктээр нэмэгдэж, түүнээс дээш бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 30.9 хувь болж өнгөрсөн оныхоос 1.6 пунктээр буурсан байна. Цас, зудын хүндрэлтэй байсан 2000-2002 онуудад 100 хүртэл буюу харьцангуй цөөн малтай өрхийн тоо жил тутам нэмэгдэж, түүнээс дээшхи бүлгийнх буурсаар байна. 2002 онд 13.4 мянган өрх малгүй болж, цөөн малтай өрхийн эзлэх хувь нэмэгдэж байгаагаас үзэхэд хөдөөд ядуурал нэмэгдэх нөхцөл байдал үүссэнийг харуулав. (Хавсралт 4, 6)

Иргэдийн хувийн малын бүлэглэлт*

	Малтай өрхийн тоо			Дүнд эзлэх %			Малын тоо /мян.тол/		
	2000	2001	2002	2000	2001	2002	2000	2001	2002
ДҮН	268 732	256 550	243 234	100.0	100.0	100.0	29 236.7	25 335.6	23 280.0
10 хүртэл малтай	31 361	33 797	33183	11.7	13.2	13.6	184.0	186.6	185.5
11-30 малтай	40 436	43 082	42796	15.0	16.8	17.6	833.1	877.6	878.6
31-50 малтай	35 041	36 030	36165	13.0	14.0	14.9	1 431.5	1 450.2	1458.8
51-100 малтай	63 096	60 195	55905	23.5	23.5	23.0	4 714.7	4 448.6	4059.7
101-200 малтай	59 821	51 383	46051	22.3	20.0	18.9	8 424.9	7 308.6	6502.3
201-500 малтай	33 408	27 949	25313	12.4	10.9	10.4	9 607.5	8 028.9	7358.2
501-999 малтай	4 591	3 406	3160	1.7	1.3	1.3	2 870.7	2 179.1	2033.3
1000-1499 малтай	893	639	601	0.3	0.2	0.2	1 004.8	720.4	684.7
1500-2000 малтай	48	38	36	0.0	0.0	0.0	79.5	62.6	61.4
2001-ээс дээш малтай	37	31	24	0.0	0.0	0.0	85.9	72.8	57.3

* Бүлэглэлтэд алдуул мал ороогүй

Бүс нутгаар авч үзвэл: мөн 100 хүртэл малтай ядуу өрхийн тоо Баруун бүсэд өмнөх оныхоос 0.9 мянгаар нэмэгдэж, бусад бүсэд 0.4-2.8 мянгаар буурсан байна.

100 хүртэл малтай нийт ядуу өрхийн 38.5 хувь нь Хангайн бүсэд, 27.1 хувь нь Баруун бүсэд, 19.7 хувь нь Төвийн бүсэд, 10.8 хувь нь Зүүн бүсэд, 3.9 хувь нь Улаанбаатарт байна.

Аймгаар авч үзвэл: Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Өмнөговь, Дархан-Уул аймгуудад 100 хүртэл малтай өрхийн тоо өмнөх оныхоос нэмэгдсэн байна. Эндээс харахад цас, зудтай байсан дээрхи аймгуудад малын хорогдол их гарснаар 100 хүртэл малтай өрхийн тоо жил бүр нэмэгдэж, түүнээс дээш бүлгийнх жилээс жилд буурсаар байгаа нь ажиглагдаж байна.

2002 оны тооллогоор 1000-аас дээш малтай 659 өрх тоологдсон бөгөөд үүний 235 нь Зүүн бүсэд, 148 нь Төвийн бүсэд, 142 нь Хангайн бүсэд, 134 нь Баруун бүсэд байна.

Нэг өрхөд ногдох хувийн малын бүлэглэлт

	2000	2001	2002					
			бүгд	тэмээ	адув	үхэр	хонь	ямаа
ДҮН	109	99	96	1	8	8	42	37
10 хүртэл малтай	6	5	6	0	1	2	1	1
11-30 малтай	21	20	21	0	16	1	1	2
31-50 малтай	41	40	40	0	4	5	13	17
51-100 малтай	75	74	73	1	7	7	27	31
101-200 малтай	141	142	141	2	11	10	60	58
201-500 малтай	288	287	291	3	22	16	141	109
501-999 малтай	625	640	643	7	49	34	356	197
1000-1499 малтай	1125	1127	1139	8	85	59	696	293
1500-2000 малтай	1657	1648	1707	11	131	93	966	506
2001-ээс дээш малтай	2323	2347	2389	12	191	134	1600	452

Улсын дунджаар малтай нэг өрхөд (бодод шилжүүлснээр) 29 бод буюу 96 толгой хувийн мал ногдож байгаа нь 2001 оныхоос 1 бод буюу 3 толгойгоор буурчээ. Зүүн болон Төвийн бүсийн нэг малтай өрхөд улсын дунджаас дээгүүр буюу 108-124 толгой мал, Хангай, Баруун бүс болон Улаанбаатарт улсын дунджаас доогуур буюу 31-95 толгой мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо, бүс нутгаар

	Бодод шилжүүлснээр				Толгойн тоогоор			
	1999	2000	2001	2002	1999	2000	2001	2002
ДҮН	41	37	30	29	120	109	99	96
БАРУУН БҮС								
Дүн	36	31	26	23	126	116	106	95
БӨ	24	22	21	20	88	84	81	78
ГО	39	37	32	21	163	159	145	97
ЗА	44	34	25	26	137	116	96	102
УВ	33	27	26	25	112	99	103	102
ХО	39	37	30	25	137	134	115	101
ХАНГАЙН БҮС								
Дүн	44	37	29	28	118	106	90	85
АР	44	41	32	31	103	96	84	84
БХ	42	39	27	20	146	140	98	64
БУ	53	50	42	41	130	125	121	122
ӨВ	41	27	23	21	124	91	85	81
ХӨ	42	38	28	29	101	96	80	88
ОР	27	22	23	23	73	61	71	70
ТӨВИЙН БҮС								
Дүн	59	46	32	32	182	148	105	108
ГС	35	37	18	24	94	94	69	92
ДО	59	59	43	43	162	153	132	140
ДУ	63	36	37	39	204	128	144	156
ӨМ	56	53	41	34	181	175	144	117
ДА	17	18	16	18	43	45	44	52
СЭ	19	22	20	22	49	54	57	66
ТӨ	44	41	32	32	116	111	99	100
ЗҮҮН БҮС								
Дүн	48	48	44	45	115	118	118	124
ДД	37	40	36	37	84	84	90	94
СҮ	54	57	48	49	136	139	136	141
ХЭ	50	55	45	46	119	126	122	129
УЛААНБААТАР								
УБ	12	12	11	12	29	28	28	31

Малын тооны өсөлт, бууралтад нөлөөлдөг голлох үзүүлэлтүүдийг дэлгэрүүлэн авч үзвэл дараахь байдалтай байна.

II.3. Хээлтэгч мал. 2002 оны эцэст 10479.1 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 907.1 мянгаар буурсны дотор эм хонь 577.1 мянга, эм ямаа 145.4 мянга, гүү 97.5 мянга, үнээ 77.0 мянга, ингэ 10.1 мянгаар тус тус буурлаа. Нийт бууралтын 63.6 хувийг эм хонь, 16.0 хувийг эм ямаа, 8.5 хувийг гүү эзэлж байна. Хээлтэгч мал нийт сүргийн 43.9 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 29.7 хувийг ингэ, адуун сүргийн 29.9 хувийг гүү, үхэр сүргийн 41.1 хувийг үнээ, хонь, ямаан сүргийн 45.7 хувийг эм хонь, ямаа эзэлж байна. Хээлтэгч малын 97.2 хувь нь хувийн аж ахуйд байна. (Хавсралт 19, 20, 21, 22)

Хээлтэгч малын тоо

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	мян.тол	
								2002/2001	
								%	зөрүү
ДҮН	11 771.8	13 095.5	13 925.5	14 154.4	13 244.3	11386.2	10479.1	92.0	-907.1
Ингэ	98.7	97.7	97.9	101.4	94.8	85.3	75.2	88.1	-10.1
Гүү	737.0	783.2	836.6	921.5	823.1	692.1	594.7	85.9	-97.5
Үнээ	1 215.4	1 370.8	1 432.8	1 449.8	1 214.3	850.8	773.8	90.9	-77.1
Эм хонь	5 844.1	6 370.6	6 667.9	6 846.5	6 417.9	5438.5	4861.4	89.4	-577.1
Эм ямаа	3 876.6	4 473.2	4 890.3	4 835.2	4 694.3	4319.5	4174.1	96.6	-145.4

Аймгаар авч үзвэл: хээлтэгч малын тоо Сэлэнгэ, Говьсүмбэр, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл, Дундговь аймгуудад өмнөх оныхоос өсч, бусад аймгуудад буурсан байна. Нийт хээлтэгч малын бууралтын 59.8 хувийг Баянхонгор, Говь-Алтай аймгууд эзэлж байна.

Бүс нутгаар авч үзвэл: Зүүн бүсэд хээлтэгч малын тоо өмнөх оныхоос 46.4 мянга буюу 3.0 хувиар өсч, харин бусад бүсэд хээлтэгч малын тоо өмнөх оныхоос буурсан бөгөөд үүний дотор Хангайн бүсэд 436.4 мянга буюу 11.7 хувиар, Баруун бүсэд 394.2 мянга буюу 11.8 хувиар, Төвийн бүсэд 120.7 мянга буюу 4.6 хувиар, Улаанбаатарт 2.3 мянга буюу 2.1 хувиар тус тус буурсан байна.

Баруун бүсийн нийт малын 45.5 хувийг, Хангайн бүсийн малын 42.7 хувь, Төвийн бүсийн малын 43.8 хувь, Зүүн бүсийн малын 43.4 хувь, Улаанбаатар хотын малын 44.8 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Хүснэгт 16

1993 оноос хойш хамгийн олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	он	мян.тол	он	
Ингэ	101.4	1999	Эм хонь	6 846.9	1999
Гүү	921.5	1999	Эм ямаа	4 890.3	1998
Үнээ	1 449.8	1999	Бүгд	14 154.4	1999

II.4. Төл бойжилт. 2002 онд гарсан төлийн 87.8 хувийг буюу 6808.7 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 562.0 мянгаар буюу 7.6 хувиар буурчээ. Бойжилтын хувь өнгөрсөн оныхоос 8.6 пунктээо нэмэгдсэн байна. Бойжуулсан нийт төлөөс 39.3 мянгыг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Цас зудтай байсан Баруун бүсийн бүх аймгуудад Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Хангайн бүсийн Баянхонгор, Өвөрхангай, Төвийн бүсийн Өмнөговь аймгуудад төл бойжилтын хувь улсын дунджаас доогуур буюу 58.5-87.7 хувьтай байна. (Хавсралт 23)


Хүснэгт 17

Төл бойжилт

	мян.тол								
	Бүгд			үүнээс					
	2000	2001	2002	ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	10018.3	9 310.0	7 756.0	30.0	366.3	552.2	4 099.2	2 708.3	
Бойжсон	8273.3	7 370.7	6 808.7	25.1	318.0	513.5	3 612.5	2 339.6	
Хорогдсон	1745.0	1 939.3	947.4	4.9	48.4	38.7	486.6	368.8	
Бойжилтын хувь	82.6	79.2	87.8	83.7	86.8	93.0	88.1	86.4	

Бүсээр авч үзвэл: Баруун бүсэд гарсан төлийн 77.7 хувийг, Хангайн бүсэд 88.8 хувийг, Төвийн бүсэд 93.0 хувийг, Зүүн бүсэд 94.6 хувийг, Улаанбаатарт 97.9 хувийг бойжуулсан байна. Нийт бойжуулсан төлийн 24.0 хувийг Баруун бүсэд, 33.3 хувийг Хангайн бүсэд, 24.2 хувийг Төвийн бүсэд, 17.3 хувийг Зүүн бүсэд, 1.1 хувийг Улаанбаатарт бойжуулсан байна.

Зургагт 7



Бойжуулсан төл

	МЯН.ТОЛ						
	1996	1997	1998	1999	2000	2001	2002
БҮГД	9 047.5	9 537.3	9 907.3	10220.9	8 273.3	7 370.7	6 808.7
Ботго	37.0	39.3	38.4	37.9	32.6	28.2	25.1
Унага	467.2	471.9	516.5	527.9	368.8	308.8	318
Тугал	918.1	944.6	980.0	1035.3	790.3	539.4	513.5
Хурга	4 873.3	4 946.4	5 094.5	5245.4	4 412.7	3 967.0	3612.5
Ишиг	2 751.9	3 135.1	3 277.9	3374.4	2 668.9	2 527.4	2339.6

Хүснэгт 19

1993 оноос хойш хамгийн олон төл бойжуулсан жил

	МЯН.ТОЛ	ОН		МЯН.ТОЛ	ОН
Бүгд	10 220.9	1999	Тугал	1 035.3	1999
Ботго	40.5	1995	Хурга	5 245.7	1999
Унага	527.9	1999	Ишиг	3 374.4	1999

2002 онд улсын дунджаар 100 эхээс 60 төл бойжуулсан байна. Үүний дотор 100 эхээс ботго 30, унага 46, тугал 60, хурга 66, ишиг 54 -ыг тус тус бойжуулсан байна. 2002 онд 100 эхээс бойжуулсан төлийг өмнөх оныхтой зэрэгцүүлж үзвэл бүх төрөл дээрээ өссөн хэдий ч малын тоо хамгийн өндөр байсан 1999 онтой харьцуулбал 14 төлөөр буюу 21.0 хувиар бага байна. (Хавсралт 24)

Хүснэгт 20

100 эхээс бойжуулсан төл

	1996	1997	1998	1999	2000	2001	2002
БҮГД	78	81	76	74	59	56	60
Ботго	37	40	39	39	32	30	30
Унага	66	64	66	63	40	38	46
Тугал	78	78	72	72	55	44	60
Хурга	82	85	80	79	65	62	66
Ишиг	76	81	73	69	55	54	54

Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Ховд, Баян-Өлгий аймгуудад 100 эхээс бойжуулсан төл нь улсын дунджаас доогуур байна. Дээрхи аймгуудад 100 эхээс бойжуулсан төл буурсан нь жил дараалан зуд болсон, хээлтэгч малын хорогдол их хэмжээгээр гарсан зэрэгтэй холбоотой юм. Харин бусад аймгуудад улсын дунджаас дээгүүр байна.

Бүсээр авч үзвэл: Баруун бүсэд 100 эхээс 49 төл, Хангайн бүсэд 61 төл, Төвийн бүсэд 63 төл, Зүүн бүсэд 75 төл, Улаанбаатарт 68 төл тус тус бойжуулсан байна. Хангай, Төв, Зүүн бүсүүд болон Улаанбаатарт 100 эхээс улсын дунджаас дээгүүр буюу 61-68 төл бойжуулсан байна. Харин Баруун бүсэд улсын дунджаас доогуур буюу 49 төл бойжуулсан байна.


II.5. Том малын зүй бус хорогдол. 2002 онд оны эхний малын 11.2 хувьтай тэнцэх 2917.6 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 2001 оныхоос 38.7 хувиар буюу 1841.3 мянгаар бага байна.

Нийт хорогдлын 44.8 хувийг ямаа, 40.2 хувийг хонь, 6.7 хувийг үхэр, 7.3 хувийг адуу, 0.9 хувийг тэмээ эзэлж байна. Тэмээ, ямааны хорогдол 2001 оныхоос 5.2-26.1 мянгаар нэмэгдэж, адуу, үхэр, хонины хорогдол 236.4-814.2 мянгаар буурсан байна. Тэмээ, ямааны хорогдол өнгөрсөн онуудаас нилээд их байгаа нь эдгээр малын тоогоор улсад тэргүүлдэг Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Ховд аймгуудад цас зудын хүндрэл гарсантай холбоотой (Хавсралт 25, 26).

Том малын зүй бус хорогдол

	МЯН. ТОЛ						
	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Бүгд	586.8	617.7	785.7	800.1	3 491.2	4 758.9	2 917.6
Тэмээ	8.4	6.0	6.3	6.9	18.5	20.5	25.7
Адуу	53.2	45.1	50.7	72.8	393.9	449.8	213.4
Үхэр	79.8	110.6	111.4	127.0	630.5	1 018.5	196.4
Хонь	288.7	278.9	344.2	344.9	1 416.9	1 988.2	1174.0
Ямаа	156.7	177.1	273.0	248.4	1 031.4	1 282.0	1308.1

Зурагт 8



Говь-Алтай аймагт 687.2 мянга, Баянхонгор 683.3 мянга, Ховдод 275.6 мянга, Өмнөговьд 227.1 мянга, Өвөрхангайд 222.8 мянга, Увсад 219.7 мянга, Баян-Өлгийд 170.0 мянган том мал хорогджээ. Дээрхи аймгуудад хорогдсон мал нь нийт хорогдлын 85.2 хувийг эзэлж байна.

Бүс нутгаар авч үзвэл : Баруун бүсэд 1443.0 мянган толгой мал буюу оны эхний малын 19.0, Хангайн бүсэд 1052.6 мянган толгой буюу оны эхний малын 12.1 хувь, Төвийн бүсэд 344.9 мянга буюу оны эхний малын 5.7 хувь, Зүүн бүсэд 72.9 мянга буюу оны эхний малын 2.0 хувь нь тус тус хорогдсон байна. Том малын зүй бус хорогдол нь Баруун бүсэд өмнөх оныхоос 321.3 мянгаар нэмэгдэж, бусад бүсэд буурсан байна. Хорогдсон малын 49.5 хувь нь Баруун бүсэд, 36.1 хувь нь Хангайн бүсэд байна.

Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь.

	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Бүгд	2.1	2.1	2.5	2.4	10.4	15.7	11.2
Тэмээ	2.3	1.7	1.8	1.9	5.2	6.3	9.0
Адуу	2.0	1.6	1.8	2.4	12.5	16.9	9.7
Үхэр	2.4	3.2	3.1	3.4	16.5	32.9	9.5
Хонь	2.1	2.1	2.4	2.3	9.3	14.3	9.8
Ямаа	1.8	1.9	2.7	2.2	9.3	12.5	13.6

Том малын зүй бус хорогдлын 6.0 хувь буюу 175.1 мянга нь өвчнөөр, 55.9 хувь буюу 1630.2 мянга нь зуд, гэнэтийн аюулаар, үлдсэн 38.1 хувь нь бусад шалтгаанаар хорогдов. Зуд, гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо өмнөх оныхоос 1063.8 мянга буюу 39.5 хувиар буурсан байна.

Зуд, гэнэтийн аюулаар хорогдсон малын 40.2 хувийг хонь, 47.9 хувийг ямаа эзэлж байна.

Зуд, гэнэтийн аюулаар хорогдсон малын 59.4 хувь нь Баруун бүсэд, 37.1 хувь нь Хангайн бүсэд, 2.9 хувь нь Төвийн бүсэд, 0.5 хувь нь Зүүн бүсэд, 0.1 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Зуд, гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	мян.тол	
								2002/2001	
								хувиар	зөрүү
бүгд	87.6	207.3	273.6	205.8	1738.7	2694.0	1630.2	60.5	-1063.8
тэмээ	1.0	1.4	1.3	1.1	7.9	6.3	12.4	196.8	6.1
адуу	8.1	12.4	13.6	16.5	214.0	261.1	97.9	37.5	-163.2
үхэр	9.5	33.4	33.4	35.7	299.4	585.9	82.9	14.1	-503.0
хонь	41.9	92.8	128.8	93.4	704.9	1158.5	655.9	56.6	-502.6
ямаа	27.1	67.2	96.5	59.1	512.5	682.2	781.1	114.5	98.9

1993 оноос хойш малын зүй бүс
хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	586.8	1996	4758.9	2001
Тэмээ	6.0	1997	25.7	2002
Адуу	41.6	1994	449.8	2001
Үхэр	78.3	1994	1018.5	2001
Хонь	278.9	1997	1988.2	2001
Ямаа	130.5	1995	1282.0	2001

II.6. Малын хээл хаялт, сувайралт. 2002 онд оны эхний хээлтэгч малын 20.1 хувь буюу 2292.8 мянга нь хээл хаяж, сувайрсан ба өмнөх оныхоос 3.9 хувиар буюу 92.0 мянган толгойгоор буурсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын 61.8 хувь нь буюу 1417.6 мянга нь сувайрсан, 38.2 хувь буюу 875.1 мянга нь хээл хаясан байна. Төл өгөөгүй хээлтэгч нь ингэ, эм ямаан дээр өмнөх оныхоос 0.4-165.2 мянгаар нэмэгдэж, бусад төрөл дээр 63.0-107.5 мянгаар буурсан байна. Сувайрсан хээлтэгчийн тоо өмнөх оныхоос 52.8 мянга буюу 3.9 хувиар нэмэгдэж, хээл хаясан малын тоо 144.8 мянга буюу 14.2 хувиар буурчээ.

Нийт төл өгөөгүй хээлтэгч малын 80.6 хувийг эм хонь, ямаа эзэлж байгаа юм.

Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад оны эхний хээлтэгч малын 22.6-28.2 хувиас, Өмнөговь аймагт нийт хээлтэгч малын 57.5 хувиас нь хээл хаялт, сувайралтын улмаас төл авч чадсангүй. (Хавсралт 27, 28, 29)

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо


	мян.тол								
	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд			Сувайрсан			Хээл хаясан		
	2001	2002	2002 % 2001	2001	2002	2002 % 2001	2001	2002	2002 % 2001
ДҮН	2 384.8	2 292.8	96.1	1 364.8	1 417.6	103.9	1019.9	875.1	85.8
Ингэ	10.9	11.3	103.7	8.8	9.0	102.3	2.1	2.2	104.8
Гүү	287.1	224.1	78.1	176.3	154.0	87.4	110.8	70.1	63.3
Үнээ	317.5	210.0	66.1	216.6	156.4	72.2	100.9	53.6	53.1
Эм хонь	839.9	752.8	89.6	524.2	542.1	103.4	315.7	210.7	66.7
Эм ямаа	929.4	1 094.6	117.8	438.9	556.1	126.7	490.5	538.5	109.8

Бүс нутгаар авч үзвэл: Баруун бүсэд төл өгөөгүй хээлтэгч малын тоо өмнөх оныхоос 114.5 мянгаар нэмэгдэж, бусад бүсэд 1.6-135.3 мянгаар буурсан байна. Баруун бүсэд оны эхний хээлтэгчийн 21.9 хувь буюу 733.2 мянга, Хангайн бүсэд оны эхний хээлтэгчийн 19.4 хувь буюу 724.9 мянга, Төвийн бүсэд оны эхний хээлтэгчийн 22.6 хувь буюу 594.7 мянга, Зүүн бүсэд оны эхний хээлтэгчийн 14.1 хувь буюу 220.4 мянга, Улаанбаатарт оны эхний хээлтэгчийн 18.4 хувь буюу 19.6 мянган хээлтэгч хээл хаяж, сувайрсаны улмаас төл өгөөгүй байна.

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь.

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд			Сувайрсан			Хээл хаясан		
	2000	2001	2002	2000	2001	2002	2000	2001	2002
ДҮН	19.1	18	20.1	10.6	10.3	12.5	8.5	7.7	7.7
Ингэ	10.3	11.5	13.2	8.4	9.3	10.6	1.9	2.2	2.6
Гүү	35.7	34.9	32.4	22.4	21.4	22.2	13.3	13.5	10.1
Үнээ	24.1	26.1	24.7	17.2	17.8	18.4	6.8	8.3	6.3
Эм хонь	13.2	13.1	13.8	8.4	8.2	10.0	4.8	4.9	3.9
Эм ямаа	22.9	19.8	25.3	9.3	9.3	12.9	13.5	10.4	12.5

Зурagt 9



Хүснэгт 27

1993 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	582.7	1997	2 699.9	2000
Ингэ	8.5	1998	16.2	1993
Гүү	152.3	1995	329.1	2000
Үнээ	181.1	1995	348.8	2000
Эм хонь	512.0	1996	906.0	2000
Эм ямаа	332.9	1995	1105.5	2000

II.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормын дагуу, харин бог малын хувьд нилээд алдагдсаар байна. Тухайлбал: Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 59 эм хонь, ямаа ногдож байгаа нь 2 дахин өндөр үзүүлэлт байна.

Хээлтүүлэгч малын тоо өнгөрсөн онохоос 3.7 мянгаар буюу 1.3 хувиар буурсан бөгөөд сүүлийн жилүүдэд хээлтүүлэгч малын тоо тасралтгүй буурсаар байна (Хавсралт 30).

Хүснэгт 28

Хээлтүүлэгч малын тоо

МЯН.ТОЛ

	Бүгд						үүнээс шинээр тавьсан			
	1999	2000	2001	2002	<u>2002</u> 2001	%	1999	2000	2001	2002
ДҮН	361.1	317.5	279.7	276.0		98.7	5.0	6.7	12.5	13.5
Буур	4.7	4.4	3.9	3.7		94.9	0.1	0.0	0.0	0.1
Азарга	123.3	112.6	99.7	91.2		91.5	1.3	0.8	0.8	1.2
Бух	56.3	43.5	28.5	26.9		94.4	1.1	1.0	0.8	1.3
Хуц	101.9	90.2	83.4	82.8		99.3	1.6	2.9	6.5	5.8
Ухна	74.9	66.8	64.2	71.4		111.2	0.9	2.0	4.4	5.1

Бог малын нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо Баян-Өлгий, Орхон аймгуудаас бусад бүх аймаг, хотод 2.0-3.5 дахин алдагдсан байна. Ялангуяа Говь-Алтай, Архангай, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Өмнөговь, Хэнтий, Өвөрхангай аймгуудад бог малын хээлтүүлэгч их дутагдалтай байна.

Хүснэгт 29


Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Ингэ	20-25	21	20	21	22	22	22	21
Гүү	12-15	7	7	7	8	7	7	7
Үнээ	35-45	21	23	24	26	28	30	29
Эм хонь	25-30	57	61	63	67	71	65	59
Эм ямаа	25-30	54	59	62	65	70	67	59

Бүсээр авч үзвэл: бог малын нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо бүх бүсэд нормоос хэтэрсэн байна. Ялангуяа Хангай, Зүүн бүсэд 2-3 дахин хэтрээд байна.

Зурагт 10

Бог малын хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо



II.8. Малын хэрэглээний зарлага. 2002 онд оны эхний нийт малын 23.3 хувьтай тэнцэх 6076.1 мянган малыг хэрэглээнд зарцуулсан нь өнгөрсөн оныхоос 687.3 мянган толгойгоор буурсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос буурсан нь малын тоо буурсантай холбоотой юм.

Хүнсэнд зарцуулсан малын 61.5 хувийг хонь, 24.5 хувийг ямаа, 14.0 хувийг бод мал эзэлж байна.

2002 онд оны эхний тэмээний 11.1 хувь, адууны 14.3 хувь, үхрийн 24.3 хувь, хонины 31.3 хувь, ямааны 15.5 хувийг хэрэглээнд зарцуулжээ. (Хавсралт 33).

Хүснэгт 30

Малын нийт хэрэглээний зарлага

мян.тол

	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Бүгд	7 726.3	6 920.0	7 511.4	8743.9	8 119.3	6 763.4	6 076.1
Тэмээ	38.3	35.8	30.8	31.9	47.1	45.4	31.8
Адуу	291.9	304.1	299.8	350.7	477.9	327.9	314.2
Үхэр	679.0	697.4	755.6	809.4	886.6	549.6	502.5
Хонь	4 736.0	4 055.1	4 216.7	4397.9	4 306.2	3 916.5	3 739.6
Ямаа	1 981.1	1 827.6	2 208.3	3154.0	2 401.5	1 924.0	1 488.0
Оны эхний малд эзлэх хувь:							
Бүгд	24.5	27.0	23.6	24.0	26.6	24.2	23.3
Тэмээ	8.6	10.4	10.0	8.7	9.0	13.1	11.1
Адуу	6.8	11	11.0	10.4	11.5	15.1	14.3
Үхэр	17.4	20.5	20.1	20.9	21.7	23.2	24.3
Хонь	33.6	34.5	29.9	29.8	29.9	28.3	31.3
Ямаа	16.9	23.3	20.0	21.5	28.5	21.8	15.5

Хэрэглээний зардлын 49.0 хувь буюу 2977.8 мянгыг аж ахуйн дотоодод буюу хүнсэнд, 35.9 хувь буюу 2181.4 мянгыг зах зээлд худалдан борлуулсан байна. Зах зээлд худалдан борлуулсан малын тоо өмнөх оныхоос 40.1 мянгаар нэмэгдэж, харин аж ахуйн дотоод хэрэглээ 633.0 мянгаар буурсан байна.

Энэ нь 2001 онд байгаль цаг уурын хүндрэлээс шалтгаалж мал их хэмжээгээр хорогдсон тул малчид гамшгаас сэргийлэн малаа нядалж, борлуулсантай холбоотой.

Хүснэгт 31

Зах зээлд худалдан борлуулсан, аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо

мян.тол

	зах зээлд худалдан борлуулсан				аж ахуйн дотоодод хэрэглэсэн			
	1999	2000	2001	2002	1999	2000	2001	2002
Бүгд	2 772.1	2 389.4	2 141.4	2 181.5	4 070.9	3 803.7	3 610.8	2 977.8
Тэмээ	7.1	8.8	10.7	8.3	14.4	18.4	21.1	17.1
Адуу	99.8	125.4	105.9	124.3	159.1	176.7	161.4	140.9
Үхэр	275.0	302.9	189.1	192.5	348.7	365.5	283.3	232.8
Хонь	1371.3	1 309.6	1 270.4	1 358.6	2014.1	1 988.7	1 937.4	1 646.1
Ямаа	1018.9	642.7	565.3	497.8	1534.6	1 254.4	1 207.6	940.9

Ялангуяа өвөлжилт хүндэрсэн Архангай, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Төв аймгууд болон Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Завхан, Дундговь, Говьсүмбэр аймгуудад зах зээлд худалдан борлуулсан малын тоо өссөн байна.

Бүсээр авч үзвэл: Баруун бүсэд оны эхний малын 17.1 хувь, Хангайн бүсэд 25.1 хувь, Төвийн бүсэд 26.2 хувь, Зүүн бүсэд 27.0 хувь, Улаанбаатар хотод 25.6 хувийг тус тус хэрэглээнд зарцуулсан байна.



II.9. Сүргийн бүтэц. Нийт сүргийн 30.1 хувь нь буюу 7196.2 мянга нь төл, өсвөр насны, 43.9 хувь буюу 10479.1 мянга нь хээлтэгч, 24.9 хувь нь буюу 5946.4 мянган нас гүйцсэн эр мал, 1.2 хувь нь буюу 275.9 мянга нь хээлтүүлэгч мал байна. Сүрэгт төл, өсвөр насны мал, хээлтэгч, хээлтүүлэгчийн эзлэх хувийн жин 0.1-0.2 хувиар өсч, нас гүйцсэн эр малын эзлэх хувийн жин 0.4 хувиар буурсан байна. (Хавсралт 13-17)

Хүснэгт 32


Сүргийн бүтэц, хувиар

	Төл, өсвөр насны				Нас гүйцсэн эр			
	1999	2000	2001	2002	1999	2000	2001	2002
ДҮН	33.9	29.9	30.0	30.1	22.9	25.3	25.3	24.9
Тэмээ	27.5	25.5	23.9	25.3	42.7	43.8	44.9	43.6
Адуу	32.1	27.7	25.3	30.4	34.8	37.1	38.5	35.1
Үхэр	45.8	43.8	41.5	43.3	14.9	15.6	16.1	14.2
Хонь	34.0	30.8	32.2	32.1	20.3	22.3	21.5	21.4
Ямаа	30.4	25.1	26.0	25.2	25.1	28.5	28.3	28.3

үргэлжлэл.

	Хээлтэгч				Хээлтүүлэгч			
	1999	2000	2001	2002	1999	2000	2001	2002
ДҮН	42.2	43.8	43.7	43.9	1.1	1.1	1.1	1.2
Тэмээ	28.5	29.3	29.9	29.7	1.3	1.4	1.4	1.5
Адуу	29.1	30.9	31.6	29.9	3.9	4.2	4.6	4.6
Үхэр	37.9	39.2	41.1	41.1	1.5	1.4	1.4	1.4
Хонь	45.1	46.3	45.6	45.7	0.7	0.6	0.7	0.8
Ямаа	43.8	45.7	45.0	45.7	0.7	0.7	0.7	0.8

Зурагт 12



II.2 Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

II.10. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 2002 оны эцэст цэвэр үүлдрийн 645.9 мянга, эрлийз 937.5 мянга, нутгийн шилдэг омгийн 1152.4 мянган мал тоологдов. Цэвэр үүлдрийн мал өмнөх оныхоос 10.6 хувь буюу 76.4 мянга, эрлийз мал 2.7 хувь буюу 25.7 мянгаар буурлаа. Нутгийн шилдэг омгийн мал 5.0 хувь буюу 55.0 мянгаар нэмэгдсэн байна.(Хавсралт 31, 32)

Хүснэгт 33

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо, төрлөөр, мян.тол

	1996	1997	1998	2000	2001	2002	2002/2001	
							%	зөрүү
1.Цэвэр үүлдрийн бүх мал	737.0	753.6	762.8	731.5	722.3	645.9	89.4	-76.4
үхэр	53.5	50.2	39.8	29.1	27.4	25.3	92.3	-2.1
хонь	608.1	612.0	638.8	588.5	572.2	504.2	88.1	-68.0
ямаа	75.4	91.4	84.2	113.9	122.7	116.4	94.9	-6.3
2.Эрлийз	960.7	1096.8	1128.6	1109.3	963.2	937.5	97.3	-25.7
үхэр	115.9	125.7	119.2	106.1	94.4	91.6	97.0	-2.8
хонь	654.7	751.2	795.0	760.1	594.2	545.5	91.8	-48.7
ямаа	190.1	219.9	214.4	243.1	274.6	300.4	109.4	25.8
3.Нутгийн шилдэг омгийн	695.0	762.7	698.0	791.0	1097.4	1152.4	105.0	55.0
үхэр	3.3	3.9	5.9	4.4	0.6	3.8	633.3	3.2
хонь	555.0	568	467.4	468.4	523.5	564.7	107.9	41.2
ямаа	124.9	180.2	206.5	282.0	544.1	542.4	99.7	-1.7
тэмээ	4.3	2.9	1.4	3.3	5.0	5.2	104.0	0.2
адуу	7.5	7.7	16.8	32.9	24.2	36.3	150.0	12.1

Цэвэр үүлдрийн малын 96.1 хувь, эрлийз үүлдрийн малын 90.2 хувь, нутгийн шилдэг омгийн малын 96.1 хувь нь бог мал байна.

Нийт цэвэр үүлдрийн малын 61.8 хувь нь Баруун бүсэд, 5.0 хувь нь Хангайн бүсэд, 17.2 хувь Төвийн бүсэд, 16.0 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Мөн эрлийз үүлдрийн малын 48.3 хувь нь Баруун , 16.7 хувь нь Хангайн, 20.7 хувь нь Төвийн , 14.1 хувь нь Зүүн , Улаанбаатарт 0.1 хувь нь тус тус байна.

2002 онд тоологдсон нийт үхрийн 1.3 хувь, хонины 4.7 хувь, ямааны 1.3 хувийг цэвэр үүлдрийн, үхрийн 4.9 хувь, хонины 5.1 хувь, ямааны 3.3 хувийг эрлийз , түүнчлэн хонины 5.3 хувь, ямааны 5.9 хувь, тэмээний 2.1 хувь, адууны 1.8 хувь, үхрийн 0.2 хувийг нутгийг шилдэг омгийн мал тус тус эзэлж байна.

Нийт малд цэвэр, эрлийз малын эзлэх хувийн жин үхэр, хонь, ямаан сүргийн хувьд өссөн байна.

Хүснэгт 34

Нийт малд цэвэр болон эрлийз үүлдрийн малын эзлэх хувь

	Үхэр			Хонь			Ямаа		
	2000	2001	2002	2000	2001	2002	2000	2001	2002
Бүгд	4.4	5.9	6.2	9.7	9.8	9.9	3.5	4.1	4.6
Цэвэр	0.9	1.3	1.3	4.2	4.8	4.7	1.1	1.3	1.3
Эрлийз	3.4	4.6	4.9	5.5	5.0	5.1	2.4	2.9	3.3

2002 онд цэвэр үүлдрийн хээлтэгч 357.1 мянга, эрлийз үүлдрийн 663.1 мянган хээлтэгч мал тоологдов. Цэвэр үүлдрийн хээлтэгч малын тоо өмнөх оныхоос 12.4 хувиар буюу 50.4 мянга, эрлийз үүлдрийн хээлтэгч 6.8 хувь буюу 42.4 мянгаар буурсан байна.


Нийт цэвэр, эрлийз үүлдрийн үхрийн 48.9 хувь, хонины 64.5 хувь, ямааны 68.6 хувь нь цэвэр, эрлийз үүлдрийн хээлтэгч мал байна.

Цэвэр болон эрлийз үүлдрийн хээлтэгч малын тоо, мян.тол

	1995	1998	2000	2001	2002	2002/2001	
						%	зөрүү
1.Цэвэр үүлдрийн хээлтэгч	375.4	395.4	425.2	407.5	357.1	87.6	-50.4
Үнээ	22.3	20.2	16.5	12.8	13.6	106.3	0.8
Эм хонь	312.9	332.1	359.5	341.1	273.6	80.2	-67.5
Эм ямаа	40.2	43.1	49.2	53.6	69.9	130.4	16.3
2.Эрлийз үүлдрийн хээлтэгч	425.9	595.8	659.7	620.7	663.1	106.8	42.4
Үнээ	47.7	63.1	58.2	49.3	43.6	88.4	-5.7
Эм хонь	288.2	409.2	438.3	386.5	403.6	104.4	17.1
Эм ямаа	90	123.5	163.2	184.9	215.9	116.8	31.0

Цэвэр болон эрлийз үүлдрийн малд хээлтэгчийн эзлэх хувь

	Үнээ			Эм хонь			Эм ямаа		
	2000	2001	2002	2000	2001	2002	2000	2001	2002
Бүгд	55.3	47.0	48.9	43.3	58.1	64.5	59.5	71.9	68.6
Цэвэр	56.7	46.7	53.8	61.1	58.0	54.3	43.2	56.4	60.1
Эрлийз	54.9	52.2	47.6	95.3	65.0	74.0	67.1	67.3	71.9



IV. ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2002 оны эцэст 13.3 мянган гахай, 61.6 мянган шувуу, 652 цаа буга, 307 илжиг, 1177 бүл зөгий тоологдсон нь 2001 оныхоос гахайн тоо 1.5 мянгаар буурч, шувууны тоо 7.3 мянгаар өсчээ.
(Хавсралт 38, 39, 40)

Хүснэгт 40

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрхийн тоо

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	$\frac{2002}{2001}$ %
Гахай (мян.тол)	19.1	20.8	19.9	21.9	14.7	14.8	13.3	89.9
Шувуу (мян.тол)	58.0	65.1	66.6	78.1	89.1	54.3	61.6	113.4
Цаа буга	668	619	643	662	680	644	652	101.2
Илжиг	1064	953	1510	1491	890	778	307	39.5
Зөгий (бүл)	1075	977	1057	1154	1530	1007	1177	116.9
Туулай	122	105	193	189	48	32	73	228.1
Үнэг	180	50	28	45	25	15	19	126.7
Гахайтай өрхийн тоо /мян/	3.4	2.9	2.9	3.4	2.6	2.4	1.8	75.0
Шувуутай өрхийн тоо /мян/	1.6	2.1	3.4	2.0	1.6	1.9	1.4	73.7

2002 онд аминдаа гахайтай өрх 1.8 мянга, шувуутай өрх 1.4 мянга байгаа нь 2001 оныхоос гахайтай өрх 592, шувуутай өрх 612-оор буурсан байна. Гахайны тоо болон гахайтай өрхийн тоо жил тусам буурч байгаа гол шалтгаан нь гахайг тэжээх хоол, хүнс ховордож, үнэ өртөг нь өндөр болсонтой холбоотой.

Гахайны 86.6 хувь, шувууны 29.1 хувь нь хувийн аж ахуйд байна.
Бүсээр авч үзвэл: Хангайн бүсэд гахайны тоо өсч бусад бүсэд буурсан байна. Шувууны тоо Баруун, Хангай, Зүүн бүс болон Улаанбаатарт өсч, Төвийн бүсэд буурсан байна.

Хүснэгт 41

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр. (мян.тол)

	Гахай					Үндсэн мэгж				
	2000	2001	2002	$\frac{2002}{2001}$ %	Хувийн жин	2000	2001	2002	$\frac{2002}{2001}$ %	
Дүн	14.7	14.8	13.3	89.9	100.0	4.6	3.6	3.5	97.2	
үүнээс:										
хувийн	12.9	12.9	11.5	89.1	86.5	4.3	3.1	3.2	103.2	

үргэлжлэл:

	Шувуу					Өндөглөгч				
	2000	2001	2002	$\frac{2002}{2001}$ %	Хувийн жин	2000	2001	2002	$\frac{2002}{2001}$ %	
Дүн	89.1	54.4	61.6	113.2	100.0	75.2	17.2	20.4	118.6	
үүнээс:										
хувийн	21.8	22.5	17.9	79.6	29.1	16.5	16.0	12.3	76.9	

I. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ

I.1. Малчдын тоо, насны бүлэг. 2002 оны жилийн эцсийн мал тооллогоор улсын хэмжээгээр аминдаа /хувийн/ малтай 243.2 мянган өрх байна. Үүний дотор 72.3 хувь буюу 175.9 мянга нь малчин өрх, 27.7 хувь буюу 67.3 мянга нь мал бүхий бусад өрх байна.

Малчин өрх гэдэгт жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болдог өрхийг хамруулж байгаа бөгөөд харин малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг мал бүхий өрхөд хамруулан үзэж байна.

Сүүлийн 2 жилд ган, зуд зэрэг байгалийн бэрхшээл тохиолдсноос шалтгаалан, малын тоо толгой жил дараалан буурч, үүнтэй холбоотойгоор малтай өрх, малчин өрх, малчдын тоо буурсаар байна.

2001 онтой харьцуулахад малчин өрхийн тоо 9.6 мянгаар, малчдын тоо 17.2 мянгаар буурсан байна. Харин Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудад болон Улаанбаатар хотод малчдын тоо өссөн байна.

2002 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 389.8 мян. малчид ажиллаж байгаа бөгөөд нийт малчдын 54.1 хувь нь 16-34 насны залуучууд, 32.9 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна. /Хавсралт 1/

Хүснэгт 1

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	$\frac{2002}{2001}$ %
Малтай өрх (мян.)	278.3	279.7	275.0	270.0	268.7	256.6	243.2	94.8
Малчин өрх (мян.)	170.1	183.6	187.1	189.9	191.5	185.5	175.9	94.8
Малчдын тоо (мян.)	395.4	409.6	414.4	417.7	421.4	407.0	389.8	95.8
үүнээс: 16-34 насны	226.5	223.9	231.3	233.7	235.7	224.8	210.9	93.8
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	109.2	123.4	125.4	126.8	130.3	130.7	128.2	98.1
тэтгэврийн насны	59.7	62.3	57.7	57.2	55.4	51.5	50.7	98.4
Насны бүрэлдэхүүн (%)	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	-
